

## Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулагдсан “ХҮҮХДИЙН ЭРХ-2014” 1000 хүүхдийн уулзалт, зөвлөгөөний талаарх мэдээлэл

Орхон аймгийн Засаг даргын санаачлагаар МУ-ын Их хурлын даргын ивээл дор Орхон аймгийн Эрдэнэт хотод 2014 оны 5 дугаар сарын 31-нээс 6 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Хүүхдийн эрх-2014” 1000 хүүхдийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулагдлаа.

Уулзалт зөвлөгөөнийг Хууль зүйн болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэмжиж, Орхон аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс хамтран зохион байгуулсан байна.

Уулзалт, зөвлөгөөнд 13 аймаг, нийслэлийн НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Отгонгэрэл, НЦГ-ын ГБ-ийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Ариунтуяа болон 6 дүүргийн төлөөлөгч албаны хүмүүс болон хүүхдүүд хүрэлцэн очсон байлаа. Мөн УИХ-ын Даргын Нийгмийн бодлогын зөвлөх З.Буянцогтоо, болон дээрх 2 яамны хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ЦЕГ-ын нийгмийн хэв журам хамгаалах газрын ахлах мэргэжилтэн ц.д.х Ц.Алтанхуяг нар хүрэлцэн очиж чуулганы төлөөлөгч хүүхдүүдэд хандан мэдээлэл-илтгэл тавьлаа.

Орхон аймаг нь 90 гаруй мянган хүн амтайгаас 32000 мянга нь буюу 35.8% нь хүүхэд байна. Мөн хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч болон сургууль завсардсан хүүхэдгүй юм байна.

Уулзалт, зөвлөгөөний эхний өдрийн үдээс өмнө Эрдэнэт хоттой, үдээс хойш спортын ордон, хүүхдийн ордонтой танилцах аялал зохион байгуулагдлаа. Мөн үдээс хойш 1000 хүүхэд бишгүүр хөгжмөөр “Зун цаг” нэртэй богино хэмжээний тоглолт хийсэн нь оролцогсдын бахархал, магтаалыг хүлээж байлаа.



Уулзалт, зөвлөгөөнд албаны хүмүүс мэдээлэл-илтгэл тавьсны дараа аймаг, нийслэлийн хүүхдийн төлөөлөгч 20 гаруй хүүхэд үзэл бодлоо илэрхийлж, саналаа хэллээ. Хүүхдийн хэлсэн саналыг бүлэглэн авч үзвэл 24 асуудал гарсны 14 нь албаны хүмүүст, 4 нь эцэг эхэд, 6 нь хүүхдүүд өөрсдөдөө хандсан санал, зөвлөмж, хүсэлт байлаа.

Энэхүү уулзалт, зөвлөгөөнд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид оролцсон нь нөлөөллийн, арга хэмжээний талаарх сурталчилгаа олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр мэдээлэгдсэн нь сурталчилгааны өндөр ач холбогдолтой боллоо.

Уулзалт, зөвлөгөөнд оролцогч хүүхдүүд “Зөвлөгөөний уриалга” гарсан.

Арга хэмжээний төгсгөлийн хэсэгт боловсролын салбартаа хэрэгжүүлж байгаа хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулах хөтөлбөр “Хүүхэд төлөвшлийн менежер” –ийн танилцуулга - видео кино болон Хүүхдийн Үндэсний дуу, бүжгийн чуулгын тоглолт зэргийг оролцогсдод үзүүлж сонирхуулав.



Шинээр төрсөн санаа:

1. Жил бүрийн хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон 6 дугаар сарын 1-ний өдөр хүүхдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шийдвэр гаргагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж байх
2. Жил бүр 2 удаа хүүхдүүдийг шийдвэр гаргагч нартай уулзуулж, хүүхдийн өмнө тулгамдсан асуудал болон тэдний санал, сэтгэгдэлийг сонсох ажлыг зохион байгуулж байх

Энэхүү арга хэмжээний талаарх товч мэдээллийг байгууллагын ажилтнуудад өгч, мэдээллийн хуудсыг байгууллагын вэб хуудсанд байрлууллаа. Мөн нийслэлийн Хүүхдийн холбооны ээлжит хуралдаанаар гишүүдэд нь мэдээлэл өгөхөөр төлөвлөж байна.

### **“Хүүхдийн эрх-2014” уулзалт, зөвлөгөөнд оролцогч хүүхдүүдээс гарсан санал**

1. Эцэг эх архи их хэрэглэж байгаа нь хүүхдийн эрхийг их зөрчиж байна. Хүүхдүүд үүнээс болж сурч чадахгүй байх, ирээдүйд зөв хүн болоход муугаар нөлөөлж байна
2. Хүүхэд эрүүл орчинд амьдрах эрхтэй гэдэг мөртлөө хогоо хаяж байна
3. Эцэг эх хүүхдэд буруу үлгэр дуурайл үзүүлж байна. Хүүхэд бусдаас 15%, гэр бүлээсээ 75%-ийг сурч авдаг гэдэг.
4. Хүүхэд хүчирхийлэлд өртөөд хаана хандахаа мэддэггүй
5. Хүүхдийг цэцэрлэгээс эхлэн зөв төлөвшүүлэх
6. Хүүхэд өөрөө ухамсаргүй байна, хогоо хаяхгүй байх хэрэгтэй байна
7. Сумдад хүүхдийн ажилтантай болмоор байна
8. Хүүхэд ялгаварлан гадуурхалд өртөж байна. Баянхүмүүс хүүхдийг их нээлттэй байлгаж байхад ядуу хүмүүс хязгаарлагдмал байлгадаг.
9. Гэр хороололд хүүхдийн эрх зөрчигддөг
10. Эцэг эхчүд үр хүүхэддээ анхаарал тавихгүй байна. Хүүхдээ сонсохгүй байна.
11. Багш ажилчдын үүргийг тодорхой болгож өгөөч  
Баянхонгор-Володья
12. Архений асуудлыг шийдэж өгөөч
13. Хүүхдийг архи, тамхинд уруу татаж байна
14. Шинэ дүрэмт хувцас чанар муу, үнэтэй, материал муутай
15. Хүчирхийлэлд өртөж байна, ялангуяа сургуулийн орчинд нэг нэгнээ дээрэлхдэг.  
Дорноговь-Ундрал
16. Гадаадад хүүхэд ээж, аавтайгаа байх өдөр байдаг, Монголд сард нэг удаа байдаг болмоор байна  
Дархан-Уул
17. Залуу үеэ залуу сэтгэлгээгээр хүмүүжүүлмээр байна. жишээ нь нэг удаа миний үлээж байсан шаар хагарсан чинь миний 4 настай дүү – базарваань гэсэн.
18. Засаг дарга болон ИТХ-ийн дарга нар хүүхдийн оролцооны хүүхэдтэй жилд 2-оос доошгүй удаа уулзаж, сонсож, шийдэж байх хэрэгтэй байна  
Баянгол-Төгсжаргал
19. Бие махбод оюун санааны зөрчлийг хүүхдүүд бид өөрсдөө гаргадаг.  
Хөвсгөл – Есөн-Очир
20. Хүмүүсийг ялгаварлан үзэж байна. Үүнийг больмоор байна.  
Өмнөговь
21. Хүүхэд бид хүүхдэдээ тусалж чадна. Одооноос эцэг эхчүүддээ хандаж эхэлмээр байна.
22. Эрх нь зөрчигдөж байгаа хүүхдүүдэд мэдээдлэл өгсөн зүйлүүдийг салбарууд дээр тавьж өгч байх.  
Сэлэнгэ
23. Хүүхдүүд сургууль болгон дээр 2:2 элч ажиллуулах тэд хүүхдийнхээ төлөө ажиллах.  
Дорноговь-Билэг
24. Хүүхдүүдийн үүрэг зөрчигдөж байна. Ёс заншлаа өвлөх гэтэл боломжгүй (хаяг website –д дандаа гадаадаар бичсэн юм байна гэх мэт)  
Хөвсгөл-Батчимэг
25. Хог хаягдлын асуудал дээр 100м тутамд хогийн сав байна гэсэн зорилттой мөртлөө 500м яваад байхгүй байна. 1000 хүн 1 үйлдлийн төлөө ажиллая.  
Дорноговь-Төгсбилэг

26. Хүүхдүүдээсээ хүсэх зүйл байна. Алдсан хүүхдэдээ шаардлага тавьж байя. Дутагдлын хажуугаар дуугай өнгөрөхгүй байя. Хэрэв ингэж чадахгүй бол эмгэнэл.

Төсөл

### **“Хүүхдийн эрх -2014” – 1000-н хүүхдийн уулзалт зөвлөгөөнөөс гаргасан уриалга**

Орхон аймгийн Засаг даргын санаачилгаар, УИХ-ын даргын ивээл дор Хууль зүйн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулж буй “Хүүхдийн эрх- 2014” 1000-н хүүхдийн уулзалт зөвлөгөөнд оролцсон төлөөлөгчид –**БИД**

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрөөр Хүүхдийн хөгжил хамгааллын бодлогыг анхаарлын төвд тавьж нийгэм эдийн засаг,гэр бүлийн хөгжлийн бодлоготой уялдуулан Хүүхдийг аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх нөөц боломжийг хангасан, “Хүүхдэд ээлтэй засаглал-2016”хөтөлбөрийн агуулгыг бүрэн дүүрэн хэрэгжүүлж,Хүүхдийн эрхийн конвенцед тулгуурлан эрүүл аюулгүй,айдас хүйдэсгүй дарамт шахалтгүй, хүүхэд өсөж,хөгжих, хамгаалагдах бүрэн боломж нээгдсэн**Хүүхдийн эрхийн зөрчилгүй баг, сум, аймаг** болохыг дэмжин уриалж байна.

#### **Нэг. УИХ-ын гишүүд болон төр засгийн удирдлагууд аа**

- 1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэх, Хүүхэд хамгааллын бие даасан хуультай болох
- 1.2 Хүүхдийн төлөө ажилладаг байгууллага, хүмүүсийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих
- 1.3 Хүүхдийн өөрийн оролцооны байгууллага , Хүүхдийн чиглэлээр ажиллаж байгаа ТББ-ыг дэмжин хөгжүүлэх

#### **Хоёр. Аймаг орон нутгийн ИТХ, Засаг дарга , нараа**

- 2.1 Өөрийн орон нутгийн төсөвтөө хүүхдийн хөгжил төлөвшлийг хангах үйл ажиллагааны төсвийг нэмэгдүүлэх
- 2.2 Аливаа хэлбэрээр эрх нь зөрчигдсэн хүүхдийг нийгэмшүүлэх,болон хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох
- 2.3 Хүүхдийн оролцооны байгууллагын дарга нартай жилд 2 –оос доошгүй удаа уулзаж тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байх

#### **Гурав. Төрийн болон ТББ, аж ахуйн нэгжийн төлөөлөл , аав ээж, ах эгч , үетэнгийн найз нар аа**

3.1 Хүүхэд бүр эрхээ мэдэж, үүргээ биелүүлдэг болж, зөв хайр энхрийлэлтэй, ёс зүйтэй,гэр бүлийн хүчирхийлэлгүй,хүүхдийн оролцоог дэмжсэн орчныг бий болгоход санаачилгатай оролцох

3.2.Бие биенээ дэмждэг, шинийг санаачлагч, зөв сэтгэлтэй, нийгмийнсайн сайхныг цогцлоогч байхыг уриалж байна.

Зөвлөгөөнд оролцогчид  
2014-оны 6-р сарын 01

Мэдээлэл бэлтгэсэн ГБХХХ-ийн дарга С.Байгалмаа  
2014 оны 6 дугаар сар 3